



СЭЛЭНГЭ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 21 өдөр

Дугаар А/24

Сант сум

Хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66.1, Хоршооны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.1, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 сарын 13-ны өдрийн А/361 дугаар тушаалын хавсралт “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 сарын 19-ний өдрийн 51, 52 дугаар тогтоол, Хоршоо хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах хорооны 2023 оны 03 сарын 14-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Хоршоо хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах хорооны хурлаар дэмжигдсэн 6 (зургаа) иргэн, 1 (нэг) дундын хоршоонд 36 (гучини зургаа) сарын хугацаатай, жилийн 3 хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээлийг хоршоо хөгжүүлэх сангаас олгосугай.

2. Хорооны шийдвэрээр дэмжигдсэн 6 (зургаа) иргэн, 1 (нэг) дундын хоршоонд олгох санхүүжилтийн хэмжээг хавсралтад зааснаар баталсугай.

3. Зээлдэгч нартай зээлийн болон барьцаа хөрөнгийн гэрээ байгуулж ажиллахыг Жижиг дунд үйлдвэр, худалдаа хоршоо хариуцсан мэргэжилтэний үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Оюунбат)-д, зээлийн болон барьцаа хөрөнгийн гэрээ хийгдсэн зээлдэгч нарт санхүүжилт олгохыг сан хариуцсан нягтлан бодогч (Ч.Мөнхзаяа)-д тус тус зөвшөөрсүгэй.

4. Энэхүү захирамж болон гэрээний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Жижиг дунд үйлдвэр, худалдаа хоршоо хариуцсан мэргэжилтэний үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Оюунбат), төсөл сонгон шалгаруулах хороо болон хяналтын зөвлөлд, зээлийн эргэн төлөлт, санхүүгийн тайлан мэдээг цаг хугацаанд гаргаж ажиллахыг сангийн нягтлан бодогч (Ч.Мөнхзаяа)-д даалгасугай.



С.ШИЖИРБААТАР

Боловсруулсан: *М. Оюунбат*
Хянасан: *Ч. Аюунгал*
Хувь: *1*
Огноо: *2023.03.21*

Сэлэнгэ аймгийн Сант сумын Засаг даргын 20 23
 оны 03 сарын 03 -ны өдрийн
 2023... тоот захирамжийн хавсралт

Хоршоо хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах хорооны 2023 оны 03 сарын 14-ний өдрийн хуралдааны шийдвэрээр төсөл нь дэмжигдсэн зээлдэгч нарын жагсаалт

№	Төсөл хэрэгжүүлэгчийн нэр	Төслийн нэр	Санхүүжилт	Үйл ажиллагааны чиглэл
1	Сэлэнгэ таван хайрхан дундын хоршоо	Вакумлаж боловсруулсан органик ногоо	29,660,000	органик ногоо боловсруулах
2	Ж.Цогтбаатар	Малын гаралтай бүтээгдэхүүн худалдан борлуулах	30,000,000	Суманд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн худалдах бичил зах
3	Б.Одонтуяа	хүнсний нарийн ногоо, чацаргана тариалах	10,000,000	хүнсний нарийн ногоо, жимс, жимсгэнэ тариалах
4	С.Оюунбаяр	барилгын материалын худалдаа	20,000,000	барилгын материалын худалдаа үйлчилгээ
5	Л.Амаржаргал	Жимс, жимсгэнэ боловсруулах цех	24,000,000	жимс, жимсгэнэ боловсруулах
6	З.Ойдов	Манлай	13,000,000	барилгын материал, модон эдлэл үйлдвэрлэх
7	Д.Мягмарсүрэн	хүнсний нарийн ногоо, чацаргана тариалах	5,000,000	хүнсний нарийн ногоо, жимс, жимсгэнэ тариалах
	ДҮН		131,660,000	